



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/261

Мөрөн

Урамшуулал олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” заалт, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 184 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит бус 2 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар шалгарсан байгууллагын шагналыг хавсралтаар баталсугай.

2. Шагналд зарцуулах 825,000 /найман зуун хорин таван мянган/ төгрөгийг “Эрүүл иргэн эрхэм баялаг” аймгийн дэд хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

3. Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж буй байгууллага, хамт олныг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, зөвлөн тусалж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /М.Үүрийнбаяр/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгийн газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2017 оны 05
дугаар сарын 09-ний өдрийн А/ дугаар
захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

№	Байгууллагын нэр	Зэрэглэл	Шагналын хэмжээ
1	Эрдэнэбулган сумын "Энэрэл" хүүхдийн цэцэрлэг	1-р зэрэглэл	200,000төг
2	Зоонозын өвчин судлалын төв	1-р зэрэглэл	200,000төг
3	Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль	2-р зэрэглэл	150,000төг
4	Тариалан сумын Таван толгой баг	3-р зэрэглэл	100,000 төг
5	Тариалан сумын Ар тархи баг	3-р зэрэглэл	100,000 төг
6	Өргөмжлөл	5 ширхэг 15000 төг	75000 төг
	Дүн		825,000 төг